

## Даатгалын нэр томьёо

№		Тайлбар
1	abandonment - Шилжүүлэн өгөх	Даатгуулагч нь нийт хохирлыг нэхэмжлэх зорилгоор гэмтэж сүйдсэн хөрөнгөө даатгагчид шилжүүлэх, ихэвчлэн усан тээврийн хэрэгсэлд зөвшөөрөгдөнө, усан онгоц эсвэл ачаа гэмтээд нөхөн сэргээх зардал нь даатгагдсан үнэлгээнээс давсан үед даатгуулагч хүссэн тохиолдолд хөрөнгөө даатгагчид үлдээж болно./
2	accident - Гэнэтийн осол	Урьдчилан харах боломжгүй, санамсаргүй, төсөөлөөгүй үйл явдал
3	act of God - Аюулт үзэгдэл	цахилгаан цахих, газар хөдлөх гэх мэтийн урьдчилан сэргийлэх эсвэл хамгаалах боломжгүй, хүний оролцоогүй аливаа үйл явдлын улмаас үүссэн осол, аваар
4	actual cash value - мөнгөн үнэлгээ	Дахин бий болгох болон суурилуулалтын зардлаас элэгдлийг хассан дүн
5	an actuary - Актуарч	Даатгалын хураамжийн тооцоололт, нөөцийн үнэлгээ зэрэг даатгалын холбогдолтой статистик тооцоо хийдэг мэргэжсэн хувь хүн.
6	additional insured - Нэмэлт даатгуулагч	Гэрээн дээр тодорхойлсон даатгуулагч эсвэл хөрөнгөөс бусад хувь хүний ашиг сонирхол эсвэл бусад зүйлийг нэмэлт хураамжтай эсвэл хураамжгүйгээр даатгах даатгалын гэрээний нэмэлт нөхцөл.
7	Adjacent - Хөрш зэргэлдээ	Нэг байшин нөгөөдөө маш ойр атлаа залгаагүй байх.
8	aggregate limit - Нөхөн төлбөрийн хязгаар	Эрүүл мэндийн даатгалын гэрээ, хөрөнгийн даатгалын гэрээ эсвэл хариуцлагын даатгалын гэрээгээр даатгалын гэрээний хугацаанд төлөгдөж болох нийт нөхөн төлбөрийн төлөгдөж болох дээд хэмжээ.
9	agreed amount clause - зөвшөөрсөн үнэлгээний нөхцөл	хэрэв даатгуулагч нь компаниас тодорхойлсон хэмжээний даатгалыг өөртөө даах авахыг зөвшөөрсөн тохиолдолд хамтын даатгалын нөхцөлийг зогсоохыг зөвшөөрсөн хөрөнгийн даатгалын гэрээний нөхцөл (ихэвчлэн хөрөнгийн зөвшилцөн тооцсон үнэлгээний 90 буюу түүнээс дээш хувь байдаг).
10	Apportionment - гэрээний хувиарлалт	Даатгалын тохиолдол учирсан үед эвдэрч гэмтсэн хөрөнгө нь нэгээс дээш даатгалын гэрээтэй нөхцөлд гэрээ тус бүрд хуваарилах хэмжээг тодорхойлох.
11	Arson - Галдан шатаах	Даатгалын компанийг хууран мэхлэх зорилгоор хөрөнгийг зориудаар шатаах үйл ажиллагаа
12	a bailee - Хөрөнгө түр эзэмшигч	Бусдын хөрөнгийг түр эзэмшиж буй этгээд. Тус бүрдээ харилцан адилгүй хариуцлага хүлээдэг. Жишээ нь: агуулахын манаач, цаг засварчин/
13	Binder - Урьдчилсан түр зуурын гэрээ	Даатгалын компани эсвэл даатгалын төлөөлөгчөөс гэрээ бичигдэх хүртэл түр даатгаж гаргасан хууль ёсны гэрээг хэлнэ. Энэ нь даатгалын гэрээ хийгдэх явцад бичгээр байх ба эрсдэл хүлээх компани, хугацаа, даатгалын төрөл, хэмжээг тусгасан байна.

14	a carrier - Даатгал тээгч	Даатгалын хамгаалалтыг тээж буй даатгалын компани. АНУ-д даатгагч, давхар даатгагчийг ингэж нэрлэдэг.
15	casualty insurance - Ослын даатгал	Даатгуулагчийн бусдын эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулахтай холбоотой үүсэх хуулийн хариуцлагыг даатгах даатгал юм. Энэ нь мөн шил, хулгай, дээрэм, эрчим хүчний үйлдвэр болон агаарын тээврийн даатгалыг хамардаг.
16	Catastrophe - Гамшиг	Маш их хэмжээний хохирлыг бий болгосон үйл явдал. Даатгагчийн санхүүгийн байдалд ихээр нөлөөлөх гэнэтийн, хүчтэй ширүүн /тух: шуурга, газар хөдлөлт гэх мэт/ үзэгдэл
17	catastrophe number - Гамшгийн тоо	Тодорхойлсон хэмжээнээс давсан хохирол учруулж буй гамшгийн үед хохирлын хэмжээг компанийн статистик бүртгэлд тусгайлан бүртгэнэ.
18	certificate of insurance - Даатгалын гэрчилгээ	Нэр бүхий даатгуулагчаас өөр сонирхол бүхий этгээдэд даатгуулын компаниас олгосон даатгалын нотолгоо юм. Гэрчилгээ нь мөн мастер эсвэл нээлттэй гэрээгээр даатгагдсан хөрөнгийн мэдээллийг агуулсан давхар даатгалын баталгаа болж болдог. Түүнчлэн гэрээний хуулбарыг нотлоход ашиглана.
19	co-insurance - хамтын даатгал	Гэрээ эзэмшигчээс зөвшөөрсөний дагуу даатгагдсан хөрөнгийн өртөгийн тогтсон хувьтай тэнцэх даатгалыг хийх зорилгоор багасгасан хувиар хийх /ихэвчлэн сайн дурын байна/ даатгалын гэрээний нөхцөл юм. Нэгээс олон даатгагч ижил эрсдлээр даатгуулагчтай шууд гэрээ байгуулах. Америкийн нэр томъёогоор зарим үед өөрийн даатгал гэж нэрлэдэг.
20	common law - Нийтлэг хууль /эх газрын хууль/	Шүүхээс хүлээн зөвшөөрөгдөж нотлогдсон, хэрэглээ болон уламжлал дээр суурилагдсан хууль. Үүний эсрэг нь хууль тогтоох байгууллагаар батлагдсан хууль ёсны хууль болно.
21	comparative negligence - Харьцангуй хайнга байдал	Энэхүү номлолын дагуу хайнга байдлаас үүссэн ямар нэгэн үйл явдлаас шалтгаалан хүний эрүүл мэнд, амь нас, эд хөрөнгөд учирсан хохирлыг нөхөн сэргээхэд хайнга байдлыг харгалзах ёсгүй юм. Гэвч зарга мэдүүлэгчийн хайнга байдлын хэм хэмжээнээс шалтгаалан хохирлын нөхөн төлбөрийн хэмжээг багасгаж болно.
22	compulsory insurance - Заавал даатгал	Улсын хуулиар даатгуулагч бүрийг заавал даатгуулахаар заасан даатгалын хэлбэр юм. Тухайлбал Ажилтнуудын нөхөн олговрын даатгал болон Автын хариуцлагын хууль нь олон улсад хэрэглэгддэг.
23	Conditions - Нөхцөлүүд	Даатгагч болон даатгуулагчийн эрх үүрэг гэх мэтийг жагсаасан даатгалын гэрээний нөхцөлүүд юм. Жишээ нь: даатгалын тохиолдлын үе дэх үүргүүд, гэрээ цуцлах нөхцлүүд гэх мэт.
24	contributory negligence - Осолд хүргэсэн хайнга байдал	Осол гэмтлийн шалтгааныг бий болоход хүргэсэн хувь хүний ердийн анхаарал алдагдах байдал
25	Countersignature - баталгаажих гарын үсэг	Эрх бүхий төлөөлөгч эсвэл төлөөлөх этгээдийн гэрээг хүчин төгөлдөр болгохоор зурсан гарын үсэг.
26	Declaration - мэдүүлэг	даатгуулагчаас даатгагч болон түүний төлөөлөгчид гарган өгч буй баримт
27	Declarations Page - Мэдүүлгийн хуудас	Даатгалын эрсдэл болон хамралтын талаарх мэдээлэл агуулсан тусгай хуудас. Энэ нь даатгалын гэрээний

		хавтсанд хавсрагдана.
28	direct billed - шууд нэхэмжилсэн	Даатгалын хураамжийг даатгалын төлөөлөгч биш даатгалын компани шууд нэхэмжлэх
29	earned premium - орлогод тооцсон хураамж	Тухайн тайлант үеийн даатгалын хамгаалалтыг хангаж буй орлого юм. Орлогод тооцсон хураамжийг тооцох аргачлал нь : 1. хамарсан хугацааны даатгалын бүртгэгдсэн нийт хураамж, нэмэх нь 2. тухайн хугацааны эхэн дэх орлогод тооцоогүй хураамжийн нөөц, хасах нь 3. тухайн хугацааны эцэс дэх орлогод тооцоогүй хураамжийн нөөц.
30	Endorsement- нэмэлт нөхцөл	гэрээнд орсон нэмэлт өөрчлөлтийг тусгасан гэрээнд нэмэгдэх маягт
31	Exclusion- хасалт	тухайн даатгалын гэрээгээр хамгаалагдахгүй хөрөнгө, аюул осол, нөхцөлүүдийг тусгасан заалт.
32	"FAIR" plans- ФЭЙР төлөвлөгөө	Сайн дурын зах зээлд хүлээн авах боломжгүй эрсдэлийг даатгах зарим онцлог хөрөнгийн даатгалаар хангах албадсан сангийн механизм
33	Fiduciary- Итгэмжлэгч	Итгэмжлэлийн ажил эрхэлдэг этгээд.
34	flat cancellation - шууд цуцлах	Хураамжийг бүтэн буцааж гэрээг цуцлах
35	floater policy- хөвөгч гэрээ	Хөдөлгөөнт шинж бүхий хөрөнгийг гэрээнд дурдсан аль ч байршилд байх үеийн эрсдэлийг даатгах гэрээ.
36	general cover - ердийн хамралт	Янз бүрийн байршилд буй хөрөнгийг хамарсан гэрээ. Даатгуулагчаас тодорхой завсаруудад хамруулан компанид гаргах өртөгийн тайлангийн дунджаар хураамж нь илэрхийлэгддэг.
37	Hazard- аюул эрсдэл	Хохирлын магадлалыг үүсгэх эсвэл өсгөх нөхцөл орчныг бий болгох.
38	hold harmless agreement гэм хоргүй байлгах гэрээ	Нэг этгээдийн хуулийн хариуцлагыг гэрээн дэх бусад этгээдэд хамааруулдаг гэрээ
39	improvements and betterments- Засвар сайжруулалт	Түрээслэгч өөрийн зардлаар эзэмшиж буй барилгын өртөгийг нэмэгдүүлж хийсэн засвар , өөрчлөлтүүд. Энэ нь биет хөрөнгийн нэг хэсэг болох учир даатгалын тусгай заалт нөхцөлийг шаарддаггүй.
40	incurred losses- Учирсан хохирол	Өгөгдсөн хугацааны үед учирсан бүх бие даасан хохирлуудын нийт өртөг. Хэрэв хохирол нь календарийн жил эсвэл шилжилтийн жилийн сууриар бүртгэгдсэн бол учирсан хохирлыг нөөц ба өмнөх хугацааны төлбөрийн зөрүүгээр тооцно. Учирсан хохирлыг тооцох томъёолол нь 1. тухайн хугацаанд төлсөн нөхөн төлбөр, нэмэх нь 2. тухайн хугацааны төгсгөл дэх нийт шийдвэрлээгүй хохирол(нэхэмжилсэн хохирол), хасах нь 3. тухайн хугацааны эхэн дэх нийт шийдвэрлээгүй хохирол,
41	incurred but not reported losses (IBNR) - Учирсан боловч	Учирсан боловч компанидаа мэдэгдээгүй, учирсан хохиролд бүртгэгдсэн хохирлууд. Учирсан боловч

	мэдэгдээгүй хохирол	мэдэгдээгүй хохирлын нөөцийг байгуулдаг ба энэ нь ерөнхийдөө бүртгэгдсэн эсвэл орлогод тооцсон хураамжаас тодорхой хувиар тооцогддог. Энэ хохирол нь ослын даатгалд илүү түгээмэл байдаг.
42	Indemnify - нөхөн төлөх	Учирсан бодит хохирлыг буцаан төлөх.
43	inflation guard - инфляцийн хамгаалалт	Барилгын даатгалын үнийн өсөлтөөс хамгаалсан хөрөнгийн даатгалын сайн дурын хамралт. Энэ нь даатгуулагч өртөгийн өсөлтөө даатгуулах мөн хамтын даатгалын дутуу даатгалтайн алданги(торгууль) аас урьчилан сэргийлэх шалтгааны улмаас шууд өсгөхийг зөвшөөрдөг.
44	inherent vice (суурь нөхцөлөөс үүдсэн) таагүй явдал	Асуудалтай бараанаас үүдсэн хохирол
45	installment premium- цувруулж төлөх хураамж	Бүтэн хураамж төлөгдөх хүртэл даатгуулагчийн төлж буй цуврал төлбөрүүдийн нэг.
46	insurable interest- даатгуулах ашиг сонирхол	Даатгуулагчид санхүүгийн хохирол учруулахуйц даатгалын тохиолдол учрахад тухайн тохиолдлын улмаас гэмтсэн хөрөнгө эсвэл гарсан үйлдэлтэй холбогдох аливаа ашиг сонирхол эсвэл хамаарал,
47	Insurance-даатгал	Нэг тал (даатгагч) тооцоо (хураамж)хийсний үндсэн дээр нөгөө талд (даатгуулагч) тодорхой тохиолдлын (аюул эрсдэл эсвэл аюул осол) улмаас тодорхой зүйлд учрах хохирол (эрсдэл)-ийг нөхөн төлөхөөр зөвшилцсөн гэрээний харилцаа.
48	insurance company - даатгалын компани	Улсын хууль тогтоомжоор даатгагчийн үйл ажиллагаа явуулахаар эрх олгогдсон байгууллага
49	insurance policy - даатгалын гэрээ	Бичгээр байгуулсан даатгалын гэрээ
50	Insured - даатгуулагч	даатгалын гэрээнд хамрагдсан хувь хүн, хүмүүс
51	Insurer - даатгагч	даатгалын компани
52	Insuring Agreement- Даатгалын тохиролцоо	даатгуулагчийг учирч болзошгүй хохирлоос хамгаалах даатгагчийн тохиролцоог тусгасан гэрээний хэсэг. Энэ нь даатгалын гэрээний үндэс юм.
53	joint underwriting association (JUA) Даатгалын хамтын холбоо	Даатгал хийхээр хамтарсан даатгалын компаниудын групп
54	judgment rating - тооцох үнэлгээ	даатгалын зардлыг тогтооход хэрэглэгддэг хамгийн сайн тооцоо
55	Jurisdiction - Шүүх эрх мэдэл	Эрх мэдлийн хүрээ: шүүх эрх мэдлийн хүрээн дэх газар зүйн бүс байж болно.
56	Lessor- Түрээслүүлэгч	Түрээсийг баталгаажуулж буй этгээд, газрын эзэн гэх мэт.
57	Liability - Хариуцлага	1. хууль болон шүүхээс баталсан шийдвэрээр хязгаарлагдсан нөхцөл 2. Үүрэг, өр төлбөр-ихэвчлэн

		санхүүгийн 3. Үүрэг -өр төлбөрийг төлөх боломжит зардал.
58	Licensee - Эрх эзэмшигч	бусдын байранд түүний хүссэний дагуу орох зөвшөөрөлтэй этгээд.
59	Loss - хохирол	Гэрээний дагуу учирсан хохирол эсвэл нөхөн төлбөрийн нэхэмжлэлийн үр дүн
60	loss control service- Хохирлын хяналтын үйлчилгээ	Хохирлын хяналтын ажилтан даатгалын гэрээ эзэмшигчтэй хийх явцын зөвлөлдөх уулзалтууд
61	loss control survey - хохирлын хяналтын судалгаа	Даатгалын компанийн ажилтны хүсэлтээр даатгуулагч эсвэл даатгуулагч болох этгээдтэй учирч болох аюул осол/хохирлыг танин мэдэх, хяналтын байдлыг үнэлэх, шаардлагатай үед тодорхой сайжруулалт хийх талаар зөвлөх зорилгоор зохиох уулзалт.
62	loss expectancy - Хохирлын хүлээлт /Төсөөлж буй хохирол/	Даатгалын ажилтны даатгалын тохиолдлын хохирлын талаарх урьдчилсан тооцоо
63	loss payable - Төлөх боломжит хохирол	Даатгуулсан хөрөнгөд учирсан аливаа хохирлыг барьцаалан зээлдэгч зэрэг этгээдэд нөхөн төлөх даатгалын гэрээний нөхцөл. Нөхөн төлбөр нь хохирол болох үеийн тухайн хөрөнгөд ашиг сонирхол бүхий талын гэрээний нөхцөл дээр үндэслэнэ.
64	loss ratio - Хохирлын харьцаа	Хохирлыг хураамжид харьцуулсан харьцаа. Олон төрлийн хохирлын харьцаа байдаг.
65	manual rates- зардал болон бусад тооцоонд ашиглах түвшин	Даатгалын хамгаалалтын зардлыг тооцоход ашиглана.
66	manuscript policy- гар бичмэл гэрээ	стандарт хэвлэгдсэн даатгалын гэрээнээс ондоо хувиараа бэлтгэсэн эсвэл захиалж бэлтгэсэн даатгалын гэрээ. Энэ нь тусгайлан бэлтгэгдсэн гэрээ юм.
67	market value clause- Зах зээлийн өртөгийн нөхцөл	зарим эрсдлийг хамарсан хөрөнгийн даатгалд ашиглагдаж болох нөхцөл. Энэ нь даатгалын компанид гэмтсэн эсвэл сүйрсэн хөрөнгийн зах зээлийн өртөгийг хохирол учрах үеийн бодит бэлэн мөнгөний алдагдалаар хүлээн зөвшөөрөх үүргийг олгодог.
68	merit rating - чанарын түвшин	дадлага туршлагын түвшин, эсвэл хуваарийн түвшин
69	minimum premium- байж болох хамгийн бага хураамж	Тодорхой нэг гэрээг гаргахад шаардах хамгийн бага хураамжийн түвшин. үүнээс доошхи хураамж нь гэрээг дааж явах компанийн зардлыг хангахгүй
70	monoline policy - дан нөхцөлт гэрээ	Нэг даатгалын гэрээний хамралтын хэсэг, гэрээний ерөнхий нөхцөл ба мэдүүлгийг агуулна.
71	moral hazard - ёс суртахууны аюул эрсдэл	даатгуулсан хөрөнгөтэй холбоотой даатгуулагчийн хуурамч үйлдлийн улмаас хохирлын магадлалыг нэмэгдүүлж болзошгүй даатгуулагчийн зан чанар, хандлагагаас үүдэх аюул эрсдэл
72	mortgagee clause- барьцаалан зээлдэгчийн нөхцөл	Галын болон өөр бусад шууд эрсдэлд учирсан барьцаалагдсан эд хөрөнгөд хамаарах нөхцөл: 1. барьцаалан зээлдэгчийн ашиг сонирхлын хэмжээг харгалзан тооцсон төлөх нөхөн төлбөр 2. даатгуулагчийн аливаа үйлдэл эсвэл хайнга байдлын улмаас түүний эрх зөрчигдөхгүй байх 3. барьцаалан зээлдэгчийн бусад эрх болон давуу тал зэрэг зүйлүүдийг тусгасан барьцаалагдсан хөрөнгийн гал эсвэл бусад гэмтлийн даатгалын гэрээний хавсралт нөхцөл
73	mutual insurance company- Хамтын даатгалын компани	Хувьцаат хөрөнгөгүй компани. Даатгалын гэрээ эзэмшигч нь үүнийг эзэмшдэг бөгөөд тэдгээр нь итгэмжлэгч буюу удирдлагыг сонгодог
74	named insured - Нэрлэсэн даатгуулагч	Гэрээнд даатгуулагчаар тодорхойлогдсон хувь хүн, компани
75	named perils-	даатгалын гэрээнд нэр заан тусгасан аюул осол (гал түймэр, цахилгаан

	нэрлэсэн аюул осол	цахих)
76	non-admitted carriers- зөвшөөрөлгүй даатгал эрхлэгч	тухайн улсад зөвшөөрөл аваагүй даатгалын компани
77	non-concurrence- давхцахгүй байх	Ижил хөрөнгийг ижил ашиг сонирхлоор ижил эрсдлээс даатгасан даатгалын гэрээнүүдийн нөхөн төлбөр нь адил биш байна
78	non-waiver- татгалзахгүй байх	Даатгалын хохирол эсвэл гэнэтийн ослын дараа даатгалын компани даатгуулагч нарын хооронд хийгдэх гэрээ хэлцэл. Энэхүү хэлцэл нь даатгагчийн нөхөн төлбөртэй холбогдох судалгааны үйл ажиллагаанаас татгалзахгүй байх эсвэл даатгалын гэрээний аль нэг заалтыг, эсвэл аль нэг талын эрхийг хүчингүй болгохгүй байх.
79	Oblige- үүрэг өгөх	Ашиг сонирхлыг үүрэг дагалдах ёстой. Итгэмжлэгдсэн бондод ихэвчлэн ашиглагдана.
80	Obligor- үүрэг үүсгэгч	Ихэвчлэн үндсэн өр гэдэг ба үүрэг үүсгэгч нь үүргээр хязгаарлагддаг. Бондын хувьд үндсэн өр ба барьцаа нь үүрэг үүсгэгч болно.
81	Occurrence - тохиолдол	1.Гэмтэл хохирол учруулсан үр дагаварт хүргэж буй үргэлжилсэн эсвэл давтагдсан таагүй үйл явдал 2. Нэг даатгалын тохиолдлын улмаас үүдэн гарсан ижил ерөнхий нөхцөлөөс үүсэх бүх гэмтлийг тусгасан хариуцлагын даатгалын гэрээний байнгын заалт
82	other insurance clause - бусад даатгалын заалт	Тухайн хохирлыг хамарсан өөр даатгал байгаа нөхцөлд нөхөн төлбөрийг хэрхэн шийдвэрлэх талаарх даатгалын гэрээний заалт
83	outstanding losses - шийдвэрлээгүй хохирол	Даатгалын компанид мэдэгдсэн ба өртөгийг нь урьдчилан тооцсон, төлөгдөөгүй байгаа хохирол
84	package policy- багц гэрээ	Хоёр ба түүнээс дээш тооны гэрээ нэг гэрээнд багтах. Хөрөнгө хариуцлагын даатгал орох ёстой ба бусад ослын ба хөрөнгийн даатгал бас хамрагдаж болно.
85	paid losses- Төлсөн хохирол	Хохирлыг нь бодитой тооцож нэхэмжлэгчид олгосон нөхөн төлбөр
86	participating insurance- оролцоотой даатгал	Ижил эрсдэлээр бусад даатгалтай хамтран төлбөр төлдөг даатгал
87	payment plans- төлбөр хийх төлөвлөгөө	Даатгалын хураамжийг олон янзаар төлж болдог, төлөвлөгөөнд төлөх хураамжийн хэмжээ төлбөр хийх огноо зэргийг тухайн компанид тохиромжтой байдлаар зохицуулж болдог. Энэ нь гэхдээ бүх компанид бүх гэрээнд үйлчилэхгүй байж болно.
88	Peril - аюул осол	Гэрээгээр даатгагдсан хохирлын шалтгаан(гал түймэр, цахилгаан цахих)
89	physical hazard - Бодит аюул	Хүний өмчлөл эсвэл удирдлагаас үл хамаарсан эрсдлийн бүтцийн ба үйл ажиллагааны онцлог шинж буюу бодитой зүйл.
90	Pool - сан	Зөвшилцсөний үндсэн дээр тодорхой эрсдлийг хуваахаар нэгдсэн групп компани
91	preferred risk- тусгайлан үзсэн эрсдэл	тусгайлан авч үзсэн эрсдэл
92	Premium - хураамж	даатгалын гэрээ эсвэл баталгаанд төлөх төлбөр. Хураамж нь даатгалын түвшинг даатгалын тохиолдлын нэгжийн тоогоор үржүүлсэнтэй тэнцүү.
93	probable maximum loss - болзошгүй хамгийн их хохирол	даатгагчийн хүлээгдэж буй хамгийн томоохон хохирлын урьдчилсан тооцоо бөгөөд давхар даатгалын хэрэгцээг судлахад чухал хэрэгтэй. ихэвчлэн хөрөнгийн өртөгийн хувь эсвэлдолларын өртөгөөр илэрхийлэгдэнэ.
94	Producer - үйлдвэрлэгч	худалдан авагчийн бизнесийг зуучлан компанид байршуулдаг хувь хүн. Энэ нь төлөөлөгч эсвэл зуучлагч байж болно.
95	proof of loss - Хохирлын баталгаа	даатгуулагч өөрт учирсан хохирлоо нөхүүлэх, түүнтэй холбоотой баримт мэдээллийг дурдсан нэхэмжлэлийн бичмэл маягтыг гарган өгөхийг шаардсан гэрээний шаардлага.
96	pro rata cancellation -	гэрээний хугацаа дуусахаас өмнө гэрээг цуцлах систем бөгөөд

	хувь тэнцүүлсэн цуцлалт	даатгалын гэрээ эзэмшигчид үлдсэн хугацааны хураамжийг хувь тэнцүүлэн буцаадаг. Цуцлалтыг даатгалын компани хийнэ.
97	Protected - хамгаалагдсан	Галын даатгалаар, хамгаалагдсан гэдэг нь эрсдэл галын байгууллагын хамгаалалтын бүсэд байхыг, хулгайн даатгалд энэ нь хулгайн дохиололтой байхыг хэлнэ.
98	Protection- хамгаалалт	1. гэрээний нөхцөлөөр хийх даатгал буюу хамралт гэсэн үгтэй харилцан орлуулж хэрэглэдэг 2. гал хамгааллын хэрэгслээр хангагдсаныг харуулахад хэрэглэнэ.
99	proximate cause- шууд, ойрын шалтгаан	1. хохирлыг шууд үүсгэж буй шалтгаан 2. хохирол буюу гэмтлийн хамгийн давуу шалтгаан 3. шалтгаан нөхцөлийн тасралтгүй гинжин холбоо ба хөрөнгийн гэмтэл эсвэл хүмүүсийн хоорондын үйлчлэл
100	pure premium- цэвэр хураамж	Хохирлыг даатгалын хамралтад харьцуулсан харьцаа. Татвар болон зардал хамрагдахгүй.
101	rate түвшин	нэгж хэмжээний хамралтад ногдох даатгалын зардал. Энэ түвшинг хамралтын тоогоор үржүүлж хураамжийг тодорхойлно.
102	Rebating - буцаан олголт	хуулиар заасан түвшнээс доогуур үнээр гэрээ зарагдаж даатгуулагч нэг хэсэг хураамж буцаан олгогддог(эсвэл үнэ бүхий бараа олгох). Энэ нь хууль бус, ёс зүйгүй юм.
103	recovery	Хохиролтой холбоотой давхар даатгагчаас даатгагчид ирүүлсэн мөнгө, бусдаас авах эрх үүссэн мөнгө эсвэл олгосон нөхөн төлбөрийн буцаан олголт
104	Reinsurance- давхар даатгал	даатгуулагчийн өөртөө хүлээж чадах хэмжээнээс давсан хохирлоос хамгаалах зорилгоор давхар даатгагчаас давхар даатгуулагчийн худалдан авч буй хамгаалалт
105	Reinsurer- давхар даатгагч	давхар даатгал хийдэг даатгалын компани. Давхар даатгагч нь 1. зөвхөн давхар даатгал эрхэлдэг даатгалын компани 2. даатгал давхар даатгалыг хоёуланг нь эрхэлдэг компани
106	Renewal-сунгалт	нэмэлт, гэрчилгээ эсвэл шинэ гэрээгээр дуусч буй үндсэн хугацаанаас цааш гэрээг үргэлжлүүлэх
107	renewal certificate - сунгалтын гэрчилгээ	гэрээ шинэчлэгдсэн эсвэл сунгагдсаныг харуулна.
108	replacement cost insurance- сэргээх зардлын даатгал	сүйдсэн хөрөнгийг элэгдлийн хорогдолгүй сэргээх даатгал
109	Representation- мэдүүлэг	даатгагч эрсдэл гэж үзсэн нөхцөл баримтыг тусгасан даатгуулагчаас даатгагчид гарган өгч буй аман болон бичгэн мэдүүлэг
110	Retention - үлдээх хариуцлага	тухайн эрсдлээс компанид үлдээх хариуцлагын хэмжээ. нийт дүнгээс давхар даатгалыг хасна.
111	return premium - буцаах хураамж	гэрээ цуцлалт, үнийн зохицуулалт, тооцоогоор бодит хураамжаас давсан хураамж зэргээс хамааран гэрээ эзэмшигч буюу даатгуулагчид буцаах хураамжийн хэсэг
112	Risk- эрсдэл	1. Хохирлын боломж 2. даатгалын гэрээтэй холбогдох даатгуулагч эсвэл хөрөнгө
113	Robbery - дээрэм	Бусдын хувийн өмчийг хүчээр хууль бусаар авах
114	Salvage- үлдэх өртөг	1. гал болон бусад ослын улмаас хэсэгчлэн гэмтсэний дараах хөрөнгийн өртөг 2. гэмтсэн хөрөнгийн өртөгийг сайжруулах ба гэмтсэн хөрөнгийг хамгаалах.
115	schedule rating - үнэлгээний хуваарь	хөрөнгийн ба хариуцлагын даатгалын үнэлгээний арга (Эрсдэлийн тусгай шинж чанарууд дээр суурилсан үнийн ангиллыг сайжруулах).
116	self-insurance- өөртөө даатгах даатгал	компани даатгалын хөтөлбөрийн дагуу хохирлоо нөхөн төлөхөөр тодорхой хэмжээний мөнгийг тусад нь байршуулах систем

117	servicing carrier- үйлчилгээний даатгал	Даатгалын компани улсын эрсдэлийн бодлоготой холбоотой үйлчилгээ үзүүлэхээр гэрээ байгуулдаг.
118	short rate cancellation - доогуур түвшингээр цуцлах	даатгалын гэрээний үлдэх хугацаанд хамааруулан хувь тэнцүүлэхгүйгээр хураамжийг буцаах үйл ажиллагаа. Гэрээ хүчинтэй байх хугацааны хураамжийг даатгуулагч илүү төлнө. Цуцлалт даатгуулагчийн санаачлагаар хийгдсэн.
119	stock insurance company хувьцаат даатгалын компани	хувьцаа эзэмшигчийн өмчлөлд байдаг, тэдгээрийн хяналтад байдаг компани. мөн ашгийг хянана.
120	strict liability- хатуу/ шууд хариуцлага	хуурамч эсэхийг батлах шаардлагагүй хариуцлага.